



НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2011 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 83

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Засгийн газрын 1994 оны 171 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын байгууллага, байцаагчийн дүрэм”-ийн 16 дахь хэсгийн “к” заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Ажил олгогчийг мэдээллийн нэгдсэн санд бүртгэх, дугаар олгох журам”-ыг хавсралтын ёсоор баталсугай.

Хоёр. Энэхүү тушаалын “Нэг”-д заасан журмыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан мэдээллийн нэгдсэн сан болон шаардлагатай зарим програм хангамжид нэмэлт, өөрчлөлт оруулж, ажил олгогчийг мэдээллийн нэгдсэн санд зохих журмын дагуу бүртгэх нөхцлийг бүрдүүлэхийг Мэдээлэл тооцоолол, сургалтын төв /Г.Хүрэлбаатар/-д даалгасугай.

Гурав. Ажил олгогчийг мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, дугаар олгох болсонтой холбогдуулан аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэстэй нийгмийн даатгалын бүртгэлийн гэрчилгээ /НД№05/-ний хэвлэмэл маягтын зарцуулалтыг 2011 оны 02 дугаар 24-ний өдрөөр дуусгавар болгон тооцоо хийж, үлдэгдэл гэрчилгээг 2011 оны 04 дүгээр сарын 01-ний дотор татан төвлөрүүлэх арга хэмжээ авахыг Санхүү бүртгэл, хуримтлалын сангийн газар /Д.Дуулал/, Тамгын газар /Б.Энхбаяр/-т үүрэг болгосугай.

Дөрөв. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү бүртгэл, хуримтлалын сангийн газар /Д.Дуулал/, Хяналт, үнэлгээний газар /З.Цэдэнжав/-т тус тус даалгасугай.

ДАРГА



Ч.АЛТАНХУЯГ

My doc.Tushaal-2011 A-4

1000165



Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2011 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 83 тоот тушаалын хавсралт

**Ажил олгогчийг мэдээллийн нэгдсэн санд бүртгэх, дугаар олгох журам**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Энэхүү журам нь ажил олгогчийг мэдээллийн нэгдсэн санд бүртгэх, дугаар олгох үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2. Ажил олгогчийн дугаар гэж тухайн ажил олгогчийг мэдээллийн нэгдсэн санд төлөөлөх тоон дугаарыг хэлнэ.
- 1.3. Энэхүү дугаар нь тухайн ажил олгогчийн нийгмийн даатгалын тайлан, бүртгэл тооцооны баримт бичигт бичигдсэн байна.

**Хоёр. Ажил олгогчийг мэдээллийн нэгдсэн санд бүртгэж дугаар олгох**

- 2.1. Нийгмийн даатгалын хэлтэс /тасаг, байцаагч/ нь эрх бүхий байгууллагаас Улсын бүртгэлийн гэрчилгээ авч, регистрийн дугаараар бүртгэгдсэн ажил олгогчийг мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, нэг удаа дугаар олгоно.
- 2.2. Ажил олгогчийн дугаар нь улсын хэмжээнд давхардахгүй, 9 оронтой тоо байна.
- 2.3. 2011 оны 02 дугаар сарын 24-нөөс хойш шинээр нийгмийн даатгалд хамрагдсан ажил олгогчид шинээр ажил олгогчийн дугаар олгоно. Уг дугаарын эхний 2 орон нь аймаг, дүүргийн код, дараагийн 2 орон нь сумын код, үлдсэн 5 орон нь аймаг, дүүрэг /сум/-ийн нийгмийн даатгалын хэлтэс/тасаг, байцаагч/-ээс тухайн ажил олгогчид олгож буй дугаар байна. Аймаг, дүүрэг, сумын код нь мэдээллийн нэгдсэн санд нягтлан бодох бүртгэл хөтлөхөд одоо ашиглагдаж байгаа аймаг, дүүрэг, сумын код байна. Ажил олгогчийг мэдээллийн нэгдсэн санд шинээр бүртгэхэд програм хангамжаас шууд дугаарлана.
- 2.4. 2011 оны 02 дугаар сарын 24-нөөс өмнө бүртгэлтэй байсан ажил олгогчийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй байсан дугаар хэвээр байх бөгөөд энэхүү журмын 2.2.-т нийцүүлэх үүднээс мэдээллийн нэгдсэн санд програм хангамжаас урд нь 2 орон /тэг/ шууд нэмнэ.

2.5. Сумын нийгмийн даатгалын байцаагч нь ажил олгогчийг аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлж, програм хангамжаас өгөгдсөн дугаарыг ажил олгогчид олгоно.

2.6. Ажил олгогч нь өөр аймаг, дүүргийн нутаг дэвсгэрт шилжих, нэр өөрчлөгдөх тохиолдолд ажил олгогчийн дугаар өөрчлөгдөхгүй.

2.7. Ажил олгогч нэгдэх, салах буюу бусад хэлбэрээр өөрчлөн байгуулагдах явцад шинэ хуулийн этгээд үүссэн бол уг ажил олгогчид шинээр дугаар олгоно.

### **Гурав. Ажил олгогчийн дугаарыг хэрэглэх**

3.1. Тухайн ажил олгогчийн шимтгэл төлөлтийн сар, улирлын тайлан /НД№7/, даатгуулагчийн төлсөн шимтгэлийн тооцооны хуудас /НД8/-ыг үндэслэн шимтгэлийн нэгдсэн тооцоог бодох, ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн авлага, өглөгийн болон тэтгэмжийн бодолт, олголтын тооцоо, сангуудын харилцах дансны гүйлгээ, шимтгэл ногдуулсан хөдөлмөрийн хөлс, цалингийн тооцоо, сангийн мэдээ, тайлан зэрэг ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн бүртгэл, бүх тооцоо нь мэдээллийн нэгдсэн санд ажил олгогчийн дугаараар хийгдэнэ.

3.2. Ажил олгогч нь Нийгмийн даатгалын тухай хуульд заасан үүргийн дагуу гаргах “шимтгэл төлөлтийн сар, улирлын тайлан /НД№7/”, “даатгуулагчийн төлсөн шимтгэлийн тооцооны хуудас /НД№8/”, “...даатгуулагчдад ...оны... сард жирэмсний, амаржсаны тэтгэмж олгосон жагсаалт /НД№35/”, “...даатгуулагчдад ...оны... сард хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгосон жагсаалт /НД№36/”, “...-д ажиллаж байгаад нас барсан даатгуулагчийн оршуулгын тэтгэмж олгосон жагсаалт /НД№ 34/” болон сангийн харилцах дансанд шимтгэлийн мөнгө төлсөн төлбөрийн баримтанд гэрчилгээний дугаарын оронд шинээр өгөгдсөн ажил олгогчийн дугаарыг бичнэ.

3.3. Татан буугдсан, дампуурсан, үйл ажиллагаа нь зогсоогдсон ажил олгогчийн дугаарыг хадгалж, шинээр өөр ажил олгогчид олгохгүй.

### **Дөрөв. Хариуцлага**

4.1. Нийгмийн даатгалын тухай хууль болон энэ журмыг зөрчиж, ажил олгогчийн нийгмийн даатгалын тооцоо, мэдээл, тайланг будлиантуулсан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Ажил олгогчийн нэр .....

Танай байгууллагыг ..... дугаараар мэдээллийн нэгдсэн санд  
бүртгэлээ.

Байцаагч...../ /

..... оны ..... сарын .....-ний өдөр